

ГЕРОНТОЛОГИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үндэслэл ба арга зүй

Эрүүл мэндийн байгууллагын 2024 оны үйл ажиллагааны хяналт-шинжилгээ, үнэлгээг Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/346 дугаар тушаалаар баталсан “Эрүүл мэндийн салбарын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг тус тус үндэслэн гүйцэтгэсэн.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

Эрүүл мэндийн яамны харьяа агентлаг, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн 2024 оны үйл ажиллагааны гүйцэтгэлд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, гүйцэтгэлийн үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, үйл ажиллагааг сайжруулах санал, зөвлөмжөөр хангахад оршино.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн

Эрүүл мэндийн байгууллагын 2024 оны үйл ажиллагааны гүйцэтгэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээг дараах 5 чиглэлийн хүрээнд гүйцэтгэсэн болно. Үүнд:

1. Тухайн байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт;
2. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт;
3. Мэдээллийн ил тод, нээлттэй байдлын хэрэгжилт;
4. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын үзүүлэлтийн биелэлт;
5. Хэрэглэгчийн үнэлгээ.

3.1 Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө

“2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-г 11 зорилтын хүрээнд 43 үйл ажиллагаа хэрэгжүүлэхээр батлуулсан бөгөөд 60.5% нь тогтмол хийгддэг арга хэмжээ, 39.5% нь шинэ арга хэмжээнүүд байна.

Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн дундаж 66.9 %

Байгууллагад мөрдөх дүрэм, журам, стандартын жагсаалтын дагуу хяналтын хуудсууд гаргаж, тогтмол хяналт тавьсан, 9 дүүргийн өрхийн эрүүл мэндийн төвүүдэд мэргэжлийн арга зүйн дэмжлэг үзүүлж, дүүргийн эмнэлгийн мэргэжилтнүүдэд ахмад настны чиглэлээр багц цагийн сургалт зохион байгуулсаны зэрэгцээ ахмадын чиглэлийн ТББ-уудтай идэвхтэй хамтарч ажилласан байна.

Гэвч гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайланг хангалтгүй бичсэн, арга хэмжээний шалгуур үзүүлэлт, зорилтот түвшин хоорондоо уялдаагүй, ижил агуулгатай ажлыг хэд хэдэн ажил болгон тусад нь салгасан, зарим арга хэмжээг буруу тодорхойлж оруулсан, тогтмол хийгддэг ажлууд нийт төлөвлөсөн арга хэмжээний гуравны хоёр (60,5%)-ыг эзэлсэн, санхүүжилт нь тодорхойгүй ажлуудыг тусгаснаас хэрэгжиж чадаагүй зэрэг дутагдлууд байна. Мөн тус байгууллага шинэ байранд орохоор

төлөвлөсөн ч хугацаандаа орж чадаагүй нь зарим төлөвлөсөн арга хэмжээ бүрэн хэрэгжиж чадахгүйд нөлөөлсөн байж болно.

Хангалтгүй болон хэрэгжээгүй арга хэмжээ:

- Алслагдсан аймаг, дүүрэг, хороо, сум тосгоны настнуудад эрт илрүүлэг урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулах;
- ГҮТ-өөр үйлчлүүлсэн ахмад настнуудад Настны доройтлын тархалтыг судлан тогтоож, эртирүүлэг, хяналтын тогтолцоог бүрдүүлэх;
- ГҮТ-ийн тохиолдлын удирдлагын тогтолцооны төлөвлөгөөг шинэчлэн, бэлэн байдлыг хангах ажиллах;
- Ахмад настанд үзүүлэх урт хугацааны тусламж, үйлчилгээний заавар, журам боловсруулах;
- Чанарын ОУ-ын удирдлагын тогтолцооны сайн туршлага судалж, үйл ажиллагаандаа нэвтрүүлэх;
- Уян дурангийн оношилгоо, эмчилгээг нэмэгдүүлэх;
- Эмнэлзүйн лабораторийн аппаратаар хангах;
- Ахмад настны цогц тусламж үйлчилгээний үнэлгээний гар утасны аппликэшн нэвтрүүлэх;
- Настан судлалын цахим болон танхимын хөтөлбөрийг боловсруулан батлуулж төгсөлтийн өмнөх болон дараах сургалтын хөтөлбөрт оруулах;
- Настны эрүүл мэнд, нийгэм сэтгэл зүйн байдал үндэсний тойм судалгааг хийх;
- Настны зөнөх өвчний тархалт, эмнэл зүйн судалгааг хийж, урт хугацааны тусламж үйлчилгээг төлөвлөх;
- Төвийн цахим мэдээллийн аюулгүй байдалд үнэлгээ хийлгэж, эрсдлээс сэргийлэх арга хэмжээ зохион байгуулах;
- Байгууллагын санхүүгийн удирдлагыг үр ашигтай хэрэгжүүлж, өр авлагагүй ажиллах.

3.2 Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт

2024 оны үнэлгээ дунджаар 63.5%-тай байна. Албан хаагчдын гадаад сургалтын төлөвлөгөөний гүйцэтгэл хангалтгүй, 2024 онд 1 албан хаагч 1 удаа гадаад оронд сургалтад хамрагдсан нь албан хаагчдын 20%-оос дээш байх түвшинг хангахгүй ба 2%-ийг эзэлж байгаа, албан хаагчдын шилжилт хөдөлгөөн нийт албан хаагчдын 15%-аас доош хувь байхаар заасан ч 49%-тай буюу шилжилт хөдөлгөөн маш их, ажлын байрны сэтгэл ханамжийн судалгаа 54%-тай байгаа зэрэг хангалтгүй үзүүлэлттэй байна.

Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлтийг үнэлэх 12 үзүүлэлтээс 6 үзүүлэлтийн зорилтот түвшинг журамд заасан ба үлдсэн 6 үзүүлэлтийн хүрэх түвшинг байгууллага оны эхэнд тоон болон чанарын үзүүлэлтээр төлөвлөж, хэрэгжилтийн үр дүнг тайлагнахаас 3 үзүүлэлтийг зорилтот түвшингүй тайлагнасан.

3.3 Мэдээллийн ил тод, нээлттэй байдлын үнэлгээ

2024 оны жилийн эцсийн байдлаар 34.6 хувь байна.

- Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал-14.4%. Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, үйл ажиллагааны тайлан, мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, санхүүгийн хяналт, шалгалтын тайлан, акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмж; Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан; Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, бусад эрх зүйн акт; Албан тушаалын тодорхойлолт, албан тушаалтны эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албаны харилцах утасны дугаар, албаны цахим шуудангийн хаяг; Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, мэдээ; Мэдээлэл хариуцагчаас зохион байгуулах олон нийтийн арга хэмжээний хөтөлбөр зэрэг 6 мэдээллийг ил тод байршуулаагүй;

- Хүний нөөцийн мэдээллийн ил тод, нээлттэй байдал- 21.7%. Албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулах журам; Албан хаагч, ажилтны ёс зүйн дүрэм; Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ; Албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам зэрэг 4 мэдээллийг ил тод байршуулаагүй;

- Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал-66.9%. Шилэн дансны хөтлөлт, хэрэгжилт, аудитын тайлан, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээлэл; Худалдан авах ажиллагаанд хийсэн үнэлгээ болон аудит, бусад хяналт, шалгалтын тайлан, дүгнэлт; Төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, хэрэгжилт, явц, үр дүн; Мэдээлэл хариуцагчийн захиалгаар хийгдсэн судалгаа, шинжилгээний ажил, түүний тайлан зэрэг 4 мэдээллийг ил тод байршуулаагүй;

- Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал-70.0%;

- Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал-0%. Олон нийтээр хэлэлцүүлж, санал авч байгаа хууль тогтоомж болон захиргааны хэм хэмжээний актын төсөл, тэдгээрийн танилцуулга, холбогдох судалгаа, бусад байгууллага, иргэнээс өгсөн санал; Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг хүн, хуулийн этгээдэд ашиглуулах, шилжүүлэх, хувьчлах, төсвийн хөрөнгийн ашиглалт болон түүнийг ашиглалтаас гаргах, ашиглалтаас гаргаснаас орсон орлогын талаарх мэдээлэл; Нэвтрэх, ашиглахад хязгаарлалт тогтоогоогүй мэдээллийн сан дахь нээлттэй өгөгдөл; Мэдээлэл хариуцагчийн зардлаар суралцагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, суралцаж байгаа улс, сургуулийн нэр, мэргэжил, суралцах хугацаа, мэдээлэл хариуцагчаас санхүүжүүлсэн сургалтын зардлын дүн, гэрээний хэрэгжилт; Хууль болон олон улсын гэрээгээр нээлттэй байхаар заасан бусад мэдээлэл (авлигын эсрэг, хүний эрх, жендэр болон бусад) зэрэг 5 мэдээллийг ил тод байршуулаагүй;

- Байгууллагын албан ёсны цахим хуудасны тогтмол ажиллагааг хангаагүй, мэдээллийн шинэчлэл, баяжилтыг тухай бүр, цаг хугацаанд нь хийгээгүй, мэдээллүүдийг давхардуулж олон дэд цэсэнд байршуулсан, эсвэл дутуу байршуулсан болон байршуулаагүй, үнэн зөв, бүрэн, иргэнд ойлгомжтой мэдээлэл байршуулаагүй дутагдлууд байна. Зарим шалгуур үзүүлэлтийг оновчгүй тайлагнасан, мэдээллийг байршуулаагүй атлаа 100% байршуулсан гэж тайлагнасан. Мөн мэдээ, мэдээллийг байгууллагын нийгмийн сүлжээний хуудсанд

түлхүү байршуулж, албан ёсны цахим хуудасны тогтмол ажиллагааг хангахгүй орхигдуулж байна.

3.4 Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын үзүүлэлтийн биелэлт

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын үнэлгээний дүн **48.3** хувь бөгөөд өмнөх оны түвшнээс сайжраагүй, дунджаас муу дараах үзүүлэлтүүд байна. Үүнд:

1. Гэрийн тусламж авсан настны тоо (эрүүл мэндийн 4, 5 дугаар бүлгийн ахмад настан)
2. Геронтологи, гериатрийн чиглэлээр мэргэшсэн мэргэжилтний тоо (их эмч, сувилагч)
3. Ахмад настангуудыг хийн дасгал хөдөлгөөнд хамруулсан хувь, үр дүнг тооцсон эсэх

3.5 Хэрэглэгчийн үнэлгээ

2024 оны жилийн эцсийн байдлаар хэрэглэгчийн сэтгэл ханамжийн үнэлгээ дунджаар 86.6 хувь буюу 4.33 оноо байна. Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/346 дугаар тушаалын дагуу 2024 онд дотооддоо зохион байгуулсан хэрэглэгчийн үнэлгээний тайланг ирүүлээгүй.

Хэрэглэгчийн үнэлгээг хийхдээ 2024 онд амбулаторын үзлэг хийлгэж, үнэлгээ өгсөн нийт 225 хэрэглэгчийн үнэлгээнээс 117 үнэлгээг түүвэрлэж гаргасан.

Дөрөв. Цаашид анхаарах асуудал, зөвлөмж

4.1 Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тогтмол хийгддэг ажлын тоог цөөрүүлж, салбарын урт, дунд, богино хугацааны бодлогод нийцүүлэх, хууль тогтоомжоор өгсөн үүрэг даалгаврыг тусгах, үндэсний түвшиний төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн хувьд судалгаа шинжилгээний ажил, тэдгээрийн үр дүнг практикт нэвтрүүлэх ажлыг төлөвлөн хэрэгжүүлэх, орон нутгийн эрүүл мэндийн байгууллагыг мэргэжлийн арга зүйгээр ханган ажиллах, төлөвлөсөн арга хэмжээнүүдийг зорилтот түвшинд хүргэн хэрэгжүүлэхэд анхаарах шаардлагатай;

4.2 Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор батлагдсан "Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам"-ын 2.2, 2.3, 2.4 дэх хэсгийн дагуу төлөвлөгөөг боловсруулах, 4.8 дахь хэсгийг баримтлан төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн зорилтын хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтийг тоон болон чанарын үзүүлэлтээр оны эхэнд төлөвлөж, түүний дагуу жилийн эцэст тайлагнах;

4.3 Албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулахад анхаарах, нийгмийн баталгааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх, албан хаагчдын сэтгэл ханамжийн судалгааны үр дүнг үндэслэн цаашид хэрэгжүүлэх ажлыг төлөвлөн, хэрэгжилтийг ханган ажиллах;

4.4 Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2022 оны 201 дүгээр тогтоолоор баталсан "Нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж нийтлэх, шинэчлэх, хяналт тавих нийтлэг журам"-ыг хэрэгжүүлэн ажиллах;

4.5 “Төрийн байгууллагын цахим хуудсанд тавигдах шаардлага MNS6285:2017” стандартыг хангах, стандартын дагуу цахим хуудсыг ажиллуулах;

4.6 Байгууллагын албан ёсны цахим хуудсыг ажиллуулах, мэдээлэл байршуулах, шинэчлэх, хяналт тавих журмыг батлан мөрдүүлж, тогтмол ажиллуулах, мэдээллийн шинэчлэл, баяжилтыг тухай бүр, хугацаанд нь хийж, үнэн зөв, бүрэн, иргэнд ойлгомжтой мэдээллийг байршуулж хэвших, албан ёсны цахим хуудасны үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сайжруулах;

4.7 Шилэн дансны тухай хуулийн 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэсэн зарчмыг баримтлан мэдээллийг хуулийн хугацаанд үнэн зөв, бүрэн байршуулах;

4.8 Байршуулаагүй байсан буюу 0 үнэлгээ авсан мэдээллүүдийг цахим хуудсанд ил тод, бүрэн байршуулах;

4.9 Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээлэл бүлгийн 3.4-т заасан хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ, төлбөртэй үйлчилгээ, тэмдэгтийн хураамж зэрэг мэдээллийг ил тод байршуулах;

4.10 Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн 3.5-д заасан төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар үзүүлэлтийн тайлбарыг бүрэн бичих;

4.11 Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээлэл бүлгийн 3.9-д шилэн дансны хөтлөлт, хэрэгжилт, аудитын тайлан, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээллийг ил тод байршуулах;

4.12 Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээлэл бүлгийн 3.11-д заасан худалдан авах ажиллагаанд хийсэн үнэлгээ болон аудит, бусад хяналт, шалгалтын тайлан, дүгнэлт хэсэгт Үндэсний аудитын газраас хийсэн санхүүгийн аудитын тайланг ил тод байршуулах (аудитын тайланд Худалдан авах үйл ажиллагааны гүйцэтгэл байдаг болно);

4.13 Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээлэл бүлгийн 3.12-т заасан мэдээлэл хариуцагч болон захиалагч байгууллагын хүсэлтээр холбогдох этгээдийг худалдан авах ажиллагааны мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зааварчилгаагаар хангасан тухай мэдээлэл хэсэгт тухайн байгууллагаас зарласан тендертэй холбоотойгоор ирж мэдээлэл, зөвлөгөө авсан талаар ил тод байршуулах;

4.14 Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал бүлгийн 5.1-д заасан олон нийтээр хэлэлцүүлж, санал авч байгаа хууль тогтоомж болон захиргааны хэм хэмжээний актын төсөл, тэдгээрийн танилцуулга, холбогдох судалгаа, бусад байгууллага, иргэнээс өгсөн санал хэсэгт өгсөн саналын товъёог хийж, ил тод байршуулах;

4.15 Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал бүлгийн 5.7-д заасан төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг хүн, хуулийн этгээдэд ашиглуулах, шилжүүлэх, хувьчлах, төсвийн хөрөнгийн ашиглалт болон түүнийг ашиглалтаас гаргах, ашиглалтаас гаргаснаас орсон орлогын талаарх мэдээлэлд байр, талбай, тоног төхөөрөмжийн түрээс, акталсан эд хогшил, тоног төхөөрөмжийн мэдээллийг ил тод байршуулах;

4.16 Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын үзүүлэлтийг сайжруулахад анхаарч, үр дүнтэй арга хэмжээнүүдийг төлөвлөн ажиллах;

4.17 Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/346 дугаар тушаалын дагуу дотооддоо зохион байгуулсан хэрэглэгчийн үнэлгээний тайланг хугацаанд нь ирүүлэх.

Тав. Нэгдсэн үнэлгээ

№	Үзүүлэлт	Хэрэгжилтийн хувь	Жин	Оноо
1	Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт	66.9	0.2	13.4
2	ТАХ-ийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт	63.5	0.15	9.5
3	Мэдээллийн ил тод байдлыг илтгэх үзүүлэлт	34.6	0.15	5.2
4	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын үзүүлэлт	48.3	0.3	14.5
5	Хэрэглэгчийн үнэлгээ	86.6	0.2	17.3
6	Ерөнхий үзүүлэлт			59.9

Эрүүл мэндийн яам
2025 оны 04 дүгээр сар

Геронтологийн үндэсний төв			
№	Шалгуур үзүүлэлт	2023	2024
1	Гэрийн тусламж авсан настны тоо (эрүүл мэндийн 4, 5 дугаар бүлгийн ахмад настан)	413	59
2	Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан настны тоо	1903	2099
3	Эрүүл мэндийн бүлэг шилжсэн ахмадын тоо	126	130
4	Геронтологи, гериатрийн чиглэлээр мэргэшсэн мэргэжилтний тоо (их эмч, сувилагч)	"Настан судлал" мэргэшүүлэх сургалтын намрын элсэлтээр элсэлтээр 3 их эмч төгсөж, одоо 1 их эмч тус мэргэшүүлэх сургалтад хамрагдаж байна. Настны сувилахуйн мэргэшүүлэх сургалтад 3 сувилагч хамрагдаж байна	Гериатраар мэргэшсэн эмч -3 Сувилагч-5 Геронтологиор мэргэшсэн эмнэлгийн мэргэжилтэн байхгүй
5	Ахмад настангуудыг хийн дасгал хөдөлгөөнд хамруулсан хувь, үр дүнг тооцсон эсэх	Шугаман бүжгийн сургалтад хамрагдсан ахмад настан-24	0
6	Бие даах чадварын үнэлгээ хийсэн ахмад настны тоо	1270	2351
Нэгдсэн үнэлгээ		48.3	